

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:


“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайлангийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайланг хэлэлцээд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд даалгав.

2. Байгаль орчны төлөв байдлын тайланд тусгасан мэдээллийг олон нийтэд мэдээлж, тайлангийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, 2 жил тутам Засгийн газрын хуралдаанд тайлагнаж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгов.

3. Ганга, Өгий нуурын усны түвшин эрс буурч, ширгэх нөхцөл байдал үүсч байгаатай холбогдуулан нуурыг хамгаалж, сэргээхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч, уур амьсгалын болон байгаль орчны төлөв байдлын урт хугацааны өөрчлөлтийн талаарх байнгын ажиглалт, судалгаа, шинжилгээнд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт үүрэг болгов.

4. Уул уурхайн ажлын явцад эвдэрсэн газарт байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрыг бохирдуулсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоож, тэдгээрт холбогдох арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулах саналыг 5 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт оруулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР